



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 917,222.96 (есөн зуун арван долоон сая хоёр зуун хорин хоёр мянга есөн зуун жаран) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захирал Б.Гүрсоронзонд санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

2.1. Үйлдвэрийн газрын дүрмийн 4 дэх хэсгийн 4.4 дэх заалтад “...Үйлдвэрийн газрын дүрэмд орсон өөрчлөлтүүдийг хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно” гэж заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 534 дүгээр тогтоолоор орсон дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх;

2.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхийг хориглоно гэж заасны дагуу насжилт өндөртэй, он удаан жил хадгалагдсан бараа материалын хадгалалт, ашиглалтын хугацаа, хэрэглээний байдалд дүн шинжилгээ хийж, үнэ тогтоон худалдан борлуулах, акталж данснаас хасах, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.3. Ховд аймгийн Жаргалант сумын Рашаант багийн Мандах наран хороололд байрлалтай 56,810.3 м2 хэмжээ бүхий төрийн өмчийн эзэмшил газрын маргаантай асуудлыг хууль шүүхийн байгууллагаар тогтоолгон шийдвэрлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ ажиллах;

2.4. Үйлдвэрийн газрын биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй газрын ашиглалтын судалгааг хийж Газрын тухай хууль, газрын гэрээнд заасны дагуу шаардлагатай хөрөнгө оруулалт хийх, эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг шийдвэрлэх;

123006980
4-r huraldaan.docx


2.5.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар шинэчлэгдэн батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2.6.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Захиралтай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-д заасан эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгагдсан зардлаас бусад зардлыг санхүүжүүлэхгүй байх;

2.7.Гадаад албан томилолтын хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоолд заасны дагуу дээд шатны байгууллагын гадаад арга хэмжээний зардлыг хариуцахгүй байх;

2.8.Тогтоолын биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА		Б.ЦЭНГЭЛ
ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА		Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2024 оны 02 дугаар сарын 06-ны
өдрийн 5.6 дугаар тогтоолын хавсралт

**“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗАРТ ХИЙСЭН БАРИМТЫН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ,
ТҮҮНИЙГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Зөрчил, дутагдлын утга		Мөнгөн дүн (төгрөгөөр)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол зөрчсөн.		367,250,000.00	Төсвийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, ТУЗ-өөс Гүйцэтгэх захиралтай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г мөрдөж ажиллах;
2	Бүрдэл дутуу баримтаар томилолтын зардал олгосон.	Гадаад	61,008,458.99	Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоол, албан томилолтын журмыг мөрдөж ажиллах;
		Дотоод	11,241,411.00	
	Дүн		72,249,869.99	
	Үүнээс: мөрдөж буй хууль тогтоомжийг зөрчин дээд шатны байгууллагын албан тушаалтны гадаад томилолтын зардлыг байгууллагаас төлсөн.		29,778,256.70	
3	Батлагдсан журмын дагуу худалдан авалтын төлөвлөгөөнд тусгалгүй хэрэгжүүлсэн арга хэмжээ		305,997,317.00	Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах журмыг мөрдөж ажиллах;
4	Монгол Улсын хөдөлмөрийн хууль зөрчиж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд дутуу төвлөрүүлсэн байна.		71,826,007.33	Монгол Улсын хөдөлмөрийн хууль, “Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам батлах тухай” 2022 оны 253 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах;
5	ТӨБЗГ-ын тогтоол шийдвэргүйгээр батлагдсан хөрөнгө оруулалтын зардлаас урсгалд зардалд шилжүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлсэн худалдан авалт.		99,899,770.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах.
ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НИЙТ ДҮН			917,222,964.32 (есөн зуун арван долоон сая хоёр зуун хорин хоёр мянга есөн зуун жаран дөрвөн төгрөг гучин хоёр мөнгө) мянган төгрөг	